



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014. 03. 14 № 1/09

“МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ”
ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
П.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

“Монголын төмөр зам” ТӨХК-ийн 2013 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн хорооноос 2012 оны 06 сарын 21-ний өдөр “Монголын төмөр зам” ТӨХК-д ирүүлсэн 1в/1174 тоот албан бичигт Төрийн өмчийн хорооны мэргэжилтнүүдийг компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр Япон, Гонконг зэрэг улсуудад суралцуулах шаардлагатай байгаа тул түр хугацааны санхүүжилтийг гаргахыг зөвшөөрсөн байна.

Мөн энэ албан бичигтээ эргэн төлөлтийг төслийн нэгжээс хугацаа алдалгүй шилжүүлэх талаар дурьдсан байна.

Уг албан бичигт заасан зөвшөөрлийн дагуу “Монголын төмөр зам” ТӨХК нь 2012 оны 06 сарын 22-нд бэлэн мөнгөний кассаас 31,990,458 төгрөг (22,680 ам.доллар), 06 сарын 27-нд 19,384,992.50 төгрөг (13,925 ам.доллар), нийт 36,905 ам.доллар буюу 51,375,450.50 төгрөгийг олгосон байна.

“Монголын төмөр зам” ТӨХК нь уг авлагыг барагдуулахаар Төрийн өмчийн хороонд 2012 оны 08 сарын 29-нд 1/299 тоот албан бичиг, 2012 оны 10 сарын 16-нд 3/336 тоот албан бичиг, 2013 оны 01 сарын 24-нд 1/30 тоот албан бичгийг тус тус өгч удаа дараа шаардсан боловч Төрийн өмчийн хорооны 2013 оны 04 сарын 30-ны өдрийн 1а/1121 тоот албан бичгээр “Хуулийн байгууллагаар асуудлаа шийдвэрлүүлэх нь зүйтэй” гэсэн хариу өгсөн байна.

Энэ нь Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-д “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

“Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-д “аудитын явцад илэрсэн төлбөр зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 тоот тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасныг тус тус үндэслэн ШААРДАХ нь:

Авлагыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу барагдуулах арга хэмжээ авч, биелэлтийг Үндэсний аудитын газарт 2014 оны 06 сарын 30-ны дотор ирүүлэхийг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал П.Бат-Эрдэнэ, Ерөнхий нягтлан бодогч Б.Ганбат нарт даалгав.

ШИНЖЭЭЧ

Н.НЯМДАВАА